



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/53

Teren

**Эрсдэлийн харилцаа холбооны  
баг томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Гамшгийн тухай хуулийн 32 дугаар зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Монгол улсын шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн болон тайван цагт ажиллах эрсдэлийн харилцаа холбооны багийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, эрсдэлийн харилцаа холбооны багийн ажиллах чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Захирамжийг холбогдох бүрэлдэхүүнд танилцуулж, багийн гишүүдийг эрсдэлийн харилцаа холбооны тайван цагийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж онцгой комиссын хурлаар хэлэлцүүлж, батлуулахыг сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Батцогт)-д үүрэг болгосугай .


3.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэлийн түвшинд тохирсон үйл ажиллагааны заалтуудыг төлөвлөгөөнд тодотголоор оруулж, хэрэгжүүлж ажиллахыг эрсдэлийн харилцаа холбооны багийн ахлагч ( Б.Нарангарвуу)-д даалгасугай.

4.Эрсдэлийн харилцаа холбооны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг тухайн оны төсөвт тусган шийдвэрлүүлж ажиллахыг Гамшиг осол хариуцсан мэргэжилтэн (Г.Батчимэг)-д даалгасугай.

5.Тухайн захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Сумын Засаг даргын орлогч (М.Отгонбаатар) - д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР  
9072284 6715114494

Засаг даргын 024 оны 05 дугаар  
сарын 02 өдрийн А/53 Захирамжийн  
1 дүгээр хавсралт



## БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зохицуулагч: Б.Нарангарвуу /Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч/

Гишүүд:

Боловсруулалт хариуцсан ажилтан: М.Санчирмаа /Их эмч /

Мэдээллийн ажилтан: Г.Батчимэг /Байгаль орчны мэргэжилтэн /


Нийгмийн сүлжээ хариуцсан ажилтан: Г.Бямбахишиг /Нийгмийн бодлогын  
мэргэжилтэн /

Илтгэгч: Ө.Батцэцэг / Нийгмийн эрүүл мэндийн ажилтан /

Д.Нямсүрэн /ЕБС-ийн нийгмийн ажилтан /

Б.Баттуяа /СӨБ-ийн цахим сүлжээ хариуцсан мэргэжилтэн /

Засаг даргын 2024 оны 05... дугаар  
сарын 08... өдрийн 1/53 Захирамжийн  
2 дүгээр хавсралт



## БАГИЙН ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

### Зохицуулагч:

1. Мэдээлэл харилцаа холбооны ажлыг зохицуулах
2. Бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянах
3. Бүх үйл ажиллагааг хянах
4. Салбар хоорондын байгууллага болон бусад байгууллагатай хамтран ажиллах
5. Багийн гишүүдийг чадавхжуулах, энэ чиглэлээр бэлтгэл ажлыг хангах
6. Багийн гишүүдийн үйл ажиллагааны ерөнхий удирдлагаар хангах
7. Сумын онцгой комиссыг мэдээллээр хангах

### Багийн гишүүд:

#### Боловсруулалт хариуцсан ажилтан

1. Олон нийтийн хэрэгцээг судлах
2. Хэрэгцээнд суурилан мэдээллийн агуулга бэлтгэх
3. Үйл явдалтай холбоотой шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээ цуглуулах
4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хүн амын олон нийтийн сүлжээгээр харилцаж байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх
5. Эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, тэдэнд мэдээлэл түгээх, бусад мэргэжилтэнг арга зүйгээр хангах

#### Хэвлэл мэдээллийн ажилтан

1. Сумын иргэдийн мэдээлэл солилцдог харилцааны сувгийг тодорхойлох (ахмад настан, өсвөр үе, төрийн алба, малчид г.м-ийн олон нийтийн сүлжээний сувгийг тогтоох)
2. Сумын нийгмийн сүлжээг хариуцан ажиллаж мэдээлэл түгээх, сэтгэгдлийг гишүүдэд танилцуулах, асуултад хариулах
3. Аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж мэдээлэл солилцох, мэдээлэл өгөх;

#### Нийгмийн сүлжээ хариуцсан ажилтан

1. Нийгмийн сүлжээнд тандалт хийж иргэдийн юуг мэдэж байгаа, мэдэхгүй байгаа, тэдний айдас түгшүүрийг илрүүлэх;
2. Зорилтот бүлгийн хүн ам тус бүрд мэдээлэл түгээх;
3. Дүн шинжилгээ хийх
4. Буруу ташаа мэдээллийг илрүүлж аймгийн холбогдох байгууллагад хүргүүлж хариуг авч иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх;
5. Буруу ташаа мэдээллийг залруулах, хариу мэдэгдэл хийх
6. Ноцтой мэдээллийн талаар холбогдох байгууллагад мэдээлэл хүргэх

#### Илтгэгч

1. Мэдээллийг олон нийт ялангуяа зорилтот хүн амд хүргэх
2. Олон нийтийн зүгээс гарсан асуулт, саналыг багийн гишүүдэд хүргэх;
3. Сонирхсон асуултад хариулт өгөх